



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/537

Мөрөн сум

Барилга, байгууламж ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр суманд баригдсан 100 ортой дотуур байрны барилгыг байнгын ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Н.Шинэбаяр (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын
Барилга хот байгуулалтын хэлтсийн даргын үүргийг түр
орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Л.Амгаланбат (Шинэ-Идэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга)

Г.Батхүү (Боловсрол газрын Төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалт
хариуцсан ахлах арга зүйчийн албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч)

Д.Сандагдорж (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн
бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн
мэргэжилтэн)

Г.Ням-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн
хэлтсийн Архивын тасгийн Сан хөмрөгийн эрхлэгч)

Д.Аюушжав (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Эрчим хүчний
хяналтын улсын байцаагч)

Б.Гал-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Мэдээлэл
харилцаа холбооны хяналтын улсын байцаагч)

Д.Мягмарсүрэн (Аймгийн Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын Барилга техник хяналтын
улсын байцаагч)

Л.Бямбасүрэн (Аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас
хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч)

Л.Сэнгэбалжир ("Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-
ийн Шинэ-Идэр суман дахь техникч)

Х.Даваасүрэн
Г.Дэлгэрнасан

(“Эрдэнэт дулаан” ХХК-ийн механик)
(Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн
төвийн мэргэжилтэн)

Б.Цэнддэлгэр (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын ахлах
мэргэжилтэн)

Ц.Бямбатөр (Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Д.Жамсранжав (“Төгс гранд констракшн” ХХК-ийн инженер)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Б.Түмэн-Өлзий (“Идэр нумт” ХХК-ийн захирал)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Ю.Цэнгэлмөрөн (Шинэ-Идэр сумын Ерөнхий боловсролын
сургуулийн захирал)

Комиссын нарийн бичгийн дарга:

Д.Нямбат (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын
газрын мэргэжилтэн)


2.Барилга байгууламжийн ажлыг хүлээж авсантай авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Комиссын дарга (Н.Шинэбаяр)-д даалгасугай.

3.Барилга байгууламжийн ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Д.Нямбат)-д үүрэг болгосугай.

4.Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ